

## **Европын Холбооны стратегийн бие даасан байдал ба Монгол Улс**

**Цэрмаагийн Лхам**

*Эрдэм шинжилгээний дэд ажилтан  
ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн  
Улаанбаатар хот, Монгол Улс  
Цахим хаяг: [lkham\\_ts@mas.ac.mn](mailto:lkham_ts@mas.ac.mn)*

**Хураангуй:** *Европын Холбоо (ЕХ) нь гадаад тааламжгүй нөхцөл байдлын улмаас 2016 оноос хойш стратегийн бие даасан байдлаа хангах зорилго тавин ажиллаж, нэгдсэн гадаад бодлого, аюулгүй байдлын бодлого, батлан хамгаалах, эдийн засаг, технологийн салбарт томоохон өөрчлөлтийг хийж байна. Уг өгүүлэлд эдгээр өөрчлөлтийн талаар авч үзэхээс гадна энэ нь Монгол Улс ба ЕХ-ны хоёр талын харилцаанд ямар байдлаар нөлөөлөх боломжтой талаар өөрийн санал дүгнэлтийг хийх болно.*

**Түлхүүр үгс:** *Европын Холбоо, стратегийн бие даасан байдал, Монгол Улс ба Европын Холбооны хамтын ажиллагаа*

## ЕХ-ны стратегийн бие даасан байдал гэсэн ойлголтын тухай

Стратегийн бие даасан байдал гэдэг нь гадаад болон аюулгүй байдлын бодлогынхоо тэргүүлэх чиглэлийг өөрөө тодорхойлох, шийдвэр гаргах чадвартай байх, бүтэц зохион байгуулалт, улс төрийн болон материаллаг урьдчилсан нөхцөлийг шаардлагатай тохиолдолд гуравдагч талтай хамтрах буюу эсвэл бие даан хангах чадвартай байхыг хэлнэ гэж Германы эрдэмтдийн зүгээс тодорхойлсон<sup>1</sup> бол Европын Парламентаас 2020 оны 1 дүгээр сарын 20-нд батлан гаргасан шийдвэрээс үзэхэд, ЕХ-ны стратегийн бие даасан байдал гэдгийг өөрийгөө хамгаалах чадвартай зэвсэгт хүчинтэй байх, зэвсэгт хүчнээ шаардлагатай зэвсэг тоноглолоор хангах аж үйлдвэрийн хүчин чадалтай байх, зайлшгүй нөхцөлд бие даасан шийдвэр гаргах улс төрийн чадвар чадавхитай байх явдал гэж ойлгож байна. Мөн стратегийн бие даасан байдлаа хангах нь ЕХ-ны хууль ёсны, чухал зорилго гэж үзэж байна.<sup>2</sup>

## ЕХ стратегийн бие даасан байдлыг чухалчлах болсон шалтгаан

ЕХ-ны хилийн гадна, дотно өрнөж буй хямрал зөрчлүүд Европын иргэдийн амьдралд нөлөөлж, улмаар Холбооны оршин тогтнолд сорилт болж байгаа<sup>3</sup> тул тус холбоо стратегийн бие даасан байдалд хүрэх бодлого баримтлан ажиллаж байна. Чингэх болсон гол шалтгааныг тодорхой дурдвал:

Үүнд, *нэгдүгээрт*, Европ тивд оршин байгаа тогтворгүй улс орнуудад зэвсэгт мөргөлдөөн, дүрвэгсдийн асуудал бий болж байгаагаас гадна үүнтэй холбоотойгоор уг тивд зохион байгуулалттай гэмт хэрэг, жихадын терроризм, кибер халдлага, гибрид дайралт хийх явдал гарсаар байна. Тухайлбал, Украин 2014 оноос өнөөг хүртэл зэвсэгт мөргөлдөөн, хэсэгчилсэн дайны голомт хэвээр байж, үүнд нийт 13000 хүн амь үрэгдээд байна.<sup>4</sup>

*Хоёрдугаарт*, ЕХ-той шууд хил залган орших хямралтай бүс нутаг, тухайлбал Хойд Африк, Ойрхи

1 Barbara Lippert, Nicolai Ondarza, Volker Perthes, Strategische Autonomie Europas, Akteure, Handlungsfelder, Zielkonflikte, SWP-Studie, 2 Februar 2019, Berlin, S.5

2 “Европын стратегийн бие даасан байдал нь итгэл даах зэвсэгт хүчний үндсэн дээр хараат бус үйл ажиллагаа явуулах хүчин чадлаа үнэлж дүгнэх эрх чөлөө, зэвсэгт хүчнээ шаардлагатай зэвсэг тоноглолоор хангах аж үйлдвэрийн хүчин чадал, шаардлагатай нөхцөлд шийдвэр гаргах улс төрийн чадвараа бататгаж байх ЕХ-ны чадвар чадавхид тулгуурлана. Мөн энэ нь өөрийн сонирхол, үнэт зүйлсээ боломжтой нөхцөлд түншүүдийн хамтаар, аргагүй нөхцөлд өөрөө дангаар хамгаалахын тулд Европын аюулгүй байдлын төлөө илүү их хариуцлагыг өөртөө хүлээх зорилгыг тусган харуулж байна ... Стратегийн бие даасан байдлаа хангах нь Европын хууль ёсны, чухал зорилго бөгөөд цаашид Европын гадаад ба аюулгүй байдлын нэгдсэн бодлого, батлан хамгаалах бодлогын хувьд эн тэргүүний зорилго байх ёстой гэдгийг Европын Парламент батлан дэмжиж байна.” Jahresbericht über die Umsetzung der Gemeinsamen Sicherheits- und Verteidigungspolitik, P9\_TA(2020)0009 Entschließung des Europäischen Parlaments vom 15. Januar 2020 über die Umsetzung der Gemeinsamen Sicherheits- und Verteidigungspolitik (2019/2135(INI)), 15.01.2020, S.9-10.

3 Eine globale Strategie für Außen- und Sicherheitspolitik der EU, Juni 2016, S.1.

4 Heidelberg Institute of International Conflict research, Conflict barometer 2019, Heidelberg 2020, pp.36

Дорнод, Кавказ, Балкан, Газрын Дундад тэнгисийн зүүн бүс, цаашлаад шууд хиллэдэггүй Сахелийн бүс, Сомалийн хойг зэрэг бүс нутаг дахь тогтворгүй, тодорхойгүй байдал нь Европ тивийн аюулгүй байдалд шууд ба дам байдлаар аюул учруулж байна.<sup>5</sup>

*Гуравдугаарт*, Сүүлийн жилүүдэд олон улсын харилцааны цаашдын төлөв байдал улам бүр тодорхойгүй болж байгаа бөгөөд үүнийг гадны томоохон эрдэмтэд, улс төрчид нэгэн дуугаар дүгнэн хэлэх болжээ.<sup>6</sup> Тодруулбал, өнөөгийн олон улсын харилцааны либераль дэг журмын гол зарчим болсон улс орны тусгаар тогтнол, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн зөвшөөрөлгүй тохиолдолд хүч хэрэглэхгүй байх, хүний эрх, эрх чөлөө хангах, дэлхийн чөлөөт худалдааг хөгжүүлэх, цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх зарчмыг өдгөө дэлхийн томоохон улс гүрнүүд илтэд зөрчих болж, өнөөгийн глобальчлал, ардчилсан либераль тогтолцоог ганхуулж байна.<sup>7</sup> Тухайлбал, БНХАУ, ОХУ, Турк, Иран зэрэг улсууд хувиа хичээсэн түрэмгий үйлдлүүд гаргаж байна гэжээ. ОХУ-ын хувьд Украины Крымыг өөртөө нэгтгэж, олон улсын эрх зүйг ноцтой зөрчсөн төдийгүй 2015 онд Сирид цэргийн интервенц хийх замаар

дарангуйлагч Башар Аль-Ассадын дэглэмийг дэмжин тогтноулсан байна. Өөрөөр хэлбэл ОХУ уг бүс нутагт нөлөөгөө хүчээр оруулж байна гэсэн үг юм. Иран улс хөрш орнуудаа хяналтандаа оруулахын тулд тус бүс нутаг дахь террорист бүлэглэлүүдийг дэмжихэд ихээхэн хөрөнгө зарцуулж байгаа бол Турк улс өөрийн сонирхлоо хамгаалахын тулд курдуудын үндэсний эрмэлзлийн эсрэг цэргийн хүч хэрэглэж байна. Азийн бүс нутагт өмнө нь АНУ-ын бодлогоор тодорхойлогдож байсан орон зайд БНХАУ хүч түрэн орж ирж байгаа бөгөөд Хятадын “Нэг бүс, нэг зам” санаачлага бол үнэн хэрэгтээ геостратегийн санаархал гэж үзсэн байна. Хойд Солонгос зэрэг улсын шинээр цөмийн зэвсэг эзэмших үйл явцыг цөмийн их гүрнүүд хориглож дийлэхгүй байгаа нь тун аюултай юм. Гэтэл ЕХ-ны найдвартай түнш АНУ сүүлийн жилүүдэд дэлхийн бодлогод зонхилох нөлөөгөө алдсаар байгаа төдийгүй Д.Трамп Ерөнхийлөгчөөр сонгогдсоноос хойш худалдааны протекционист бодлого баримталж, НАТО-гийн түншлэлийн хувьд ч Европын аюулгүй байдлыг хангах асуудалд нөхцөл тавих болсон. Ийнхүү олон улсын харилцааны ардчилсан либераль дэглэм, глобальчлал асуудалтай тулгарч буй нь өрнөдийн ба Европын орнуудын

5 Jahresbericht über die Umsetzung der Gemeinsamen Sicherheits- und Verteidigungspolitik, P9\_TA(2020)0009 Entschließung des Europäischen Parlaments vom 15. Januar 2020 über die Umsetzung der Gemeinsamen Sicherheits- und Verteidigungspolitik (2019/2135(INI)), 15.01.2020, S.4

6 Hanns W.Maull (Hrsg.), Auflösung oder Ablösung? Die internationale Ordnung im Umbruch, SWP-Studie, Dezember 2017, Berlin, S.5; Rede von Außenminister der BRD Sigmar Gabriel in der Körber-Stiftung, „Europa in einer unbequemerer Welt“, 05.12.2017, S.4-7; Eine globale Strategie für die Außen- und Sicherheitspolitik der EU, Brüssel, 2016, S.11, 33, 38.

7 Hanns W.Maull (Hrsg.), Auflösung oder Ablösung? Die internationale Ordnung im Umbruch, SWP-Studie, Dezember 2017, Berlin, S.115-117.

аюулгүй байдал, хангалуун амьдралын үндэс суурийг ганхуулж буй хэрэг ажээ.<sup>8</sup>

Олон улсын харилцааны ийм таагүй, тодорхойгүй орчинд ЕХ-ны орнууд өөрсдийн аюулгүй байдал, сайн сайхны төлөө олон улсын тавцанд үйл ажиллагаа явуулах чадвартай байхын тулд стратегийн бие даасан байдлаа хангах зайлшгүй шаардлага тулгарчээ.

### **ЕХ-ны стратегийн бие даасан байдалд хүрэх алхмууд**

Европын Холбооны стратегийн бие даасан байдлыг хангах тухай асуудлыг 2013 оны 12 дугаар сарын 19-20-ны өдөр Брюссель хотноо хуралдсан Европын Зөвлөлийн хурлын шийдвэрт анхлан дурдсан байдаг. Үүнд “Европ батлан хамгаалах чадвараа хөгжүүлж, улмаар хадгалахын тулд батлан хамгаалах чиглэлд шинэлэг, өрсөлдөх чадвартай, технологийн ба аж үйлдвэрийн хүчирхэг, нэгдмэл бааз суурийг бий болгох хэрэгтэй байна. Энэ нь мөн стратегийн бие даасан байдлаа хангах, түншүүдтэйгээ хамтрах чадварыг нэмэгдүүлэх болно.”<sup>9</sup> гэжээ.

Үүний дараа уг асуудлыг 2016 оны 6 дугаар сард батлагдсан ЕХ-ны гадаад болон аюулгүй байдлын бодлогын тухай даян дэлхийн стратеги хэмээх баримт бичигт (үүнийг хойно 2016 оны даян дэлхийн стратеги гэж товчилно)

мөн дахин хөндсөн байдаг.<sup>10</sup> Үүнд, “Европын хилийн дотор ба гадна талд энх тайвныг дэмжиж, аюулгүй байдлыг хангах чадвартай байхын тулд зорилго, зорилтоо тодорхойлж, стратегийн бие даасан байдлыг хангах нь чухал юм. Иймд бид батлан хамгаалах, кибер аюулгүй байдал, терроризмтэй хийх тэмцэл, эрчим хүч, стратегийн коммуникацийн талаар явуулж буй үйл ажиллагаагаа эрчимжүүлнэ.”<sup>11</sup> гэж дурджээ. Мөн уг баримт бичигт ЕХ-ноос гадаад ба аюулгүй байдлын бодлогодоо баримтлах нэгдсэн сонирхол, зарчим, тэргүүлэх чиглэл буюу зорилго, үйл ажиллагааг тодорхой томъёолсон байна. Тухайлбал, *Европын энх тайван, аюулгүй байдлыг хангах, Европын иргэдийн хангалуун амьдралыг нэмэгдүүлэх, ардчиллыг бэхжүүлэх, дүрэм журамд тулгуурласан дэлхийн дэг журмыг тогтоох явдал бол ЕХ-ны гадаад, аюулгүй байдлын бодлогын үйл ажиллагааг тодорхойлох амин чухал сонирхол* юм гэжээ. Энэхүү дүрэм журамд тулгуурласан дэлхийн дэг журмыг тогтоох сонирхол гэдэг нь ЕХ өөрийн баримталдаг үнэт зүйлсийг удирдлага болгохын зэрэгцээ олон улсын эрх зүй, НҮБ-ын дүрэм, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тусгасан зарчмуудад тулгуурлан энх тайван, хүний эрх, тогтвортой хөгжил болон дэлхий нийтийн дундын эзэмшлийг чөлөөтэй эзэмших боломжоор хангаж чадах тийм дэлхийн дэг журмыг

8 Rede von Außenminister der BRD Sigmar Gabriel in der Körber-Stiftung, „Europa in einer unbequemeren Welt“, 05.12.2017, S.4.

9 Schlussfolgerungen des Europäischen Rates (Tagung vom 19./20. Dezember 2013), EUCO 217/13, Brüssel, 20.12.2013, S.7.

10 Eine globale Strategie für Außen- und Sicherheitspolitik der EU, Juni 2016, S.3.

11 Мөн тэнд, 3 дугаар тал.

тогтоох сонирхолтой гэсэн үг ажээ. Иймд ЕХ өөрийн сонирхол, үнэт зүйлсийг хамгаалах гэдгийг өргөн утгаар нь харвал, хууль эрх зүйд тулгуурласан, нээлттэй, либерал, олон улсын дэг журмыг хадгалах, бэхжүүлэх явдал гэж ойлгож болно.

Стратегийн аюулгүй байдлаа хангах гэсэн ЕХ-ны эрмэлзлийг эцсийн зорилго гэж үзэх бус харин Европын иргэдийн тайван, хангалуун амьдралыг хадгалах, нэмэгдүүлэх гэсэн эцсийн зорилгодоо хүрэх эн тэргүүний зорилго, зорилт гэж ойлговол зохилтой ажээ. Товчоор хэлбэл, тэд өөрсдийн хангалуун сайхан амьдралыг хадгалан үлдэхэд шаардагдах олон улсын харилцааны таатай орчин, дүрэм журам бүхий дэлхийн дэг журмыг тогтооход өөрсдөө хамтран эс оролцох аваас өөр бусдын тогтоосон ямар нэгэн дүрмэнд захирагдах хэрэг гарах учраас стратегийн бие даасан байдлыг эн тэргүүнд хангах шаардлагатай болжээ.

ЕХ-ны гишүүн орнууд өөр хоорондоо нягт хамтран ажиллах нь стратегийн бие даасан байдлаа хангах хамгийн чухал урьдач нөхцөл тул ЕХ-ны интеграцчиллыг нэмэгдүүлэх, үүнд нэн тэргүүнд нэгдсэн гадаад бодлого, аюулгүй байдлын бодлогын салбарт аливаа шийдвэрийг зөвхөн 100 хувийн саналаар бус олонхийн саналаар гаргах механизмыг ашиглах, гишүүн орнууд хүсэл зоригоо нэгтгэх зэрэг алхмуудыг амжилттайгаар хэрэгжүүлэх явдал болж байна.

Стратегийн бие даасан байдлаа илүү сайн хангаж, Европын үнэт зүйлс, сонирхолд нийцсэн олон улсын

харилцааны үр ашигтай орчныг хамтран бий болгохын тулд ЕХ зайлшгүй тодорхой хэмжээний чадвар, чадавхитай байх ёстой. Ерөнхийд нь нэгтгэн харахад, ЕХ доорх үндсэн гурван чиглэлд нэгдсэн чадавхи, хамтарсан чадамжтай байхыг эрмэлзэж байгаа бөгөөд үүнд, нэгдүгээрт, батлан хамгаалах салбар, хоёрдугаарт, гадаад бодлого - дипломатын салбар, гуравдугаарт, эдийн засаг, технологийн салбар орж байна.

#### *Батлан хамгаалахын салбар*

2016 оны стратегид, өнөөгийн тогтворгүй дэлхий ертөнцөд “soft power” байх нь хангалтгүй учраас аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хүчээ зузаатгах зорилгоор батлан хамгаалахын хөрөнгө санг бүрдүүлэх, батлан хамгаалах зардлын 20 хувийг зэвсэглэл, судалгаа, технологийн хөгжилд зарцуулах, өрсөлдөх чадвартай батлан хамгаалах зэвсгийн аж үйлдвэрийг байгуулах зэрэг тодорхой арга хэмжээг тусгасан байдаг.

Эдгээр ажлыг хэрэгжүүлэхээр 2016 оны 11 дүгээр сард ЕХ-ны Батлан хамгаалах үйл ажиллагааны хөтөлбөрийг гаргасан. Үүнд ЕХ-ны батлан хамгаалах зэвсгийн аж үйлдвэрт хөрөнгө оруулалтыг дэмжих, Европын Батлан хамгаалах санг үүсгэн байгуулах, 2017-2019 онд 90 сая еврогийн хуримтлал, 2020 оноос хойш жил бүр 500 сая еврогийн хуримтлал үүсгэн батлан хамгаалах салбарт судалгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.<sup>12</sup>

12 Europäischer Verteidigungs- Aktionsplan, Mitteilung der Kommission an das Europäische Parlament, den

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх анхны алхам болгож, 2017 оны 12 дугаар сард Байнгын бүтэц бүхий хамтын ажиллагаа (Permanent Structured Cooperation (PESCO))-г ЕХ-ны 25 улсын бүрэлдэхүүнтэйгээр<sup>13</sup> эхлүүлсэн нь үнэндээ ЕХ-ны Батлан хамгаалахын холбооны тулгын чулууг тавьсан хэрэг байв. PESCO-гийн гол зорилго нь зөрчил мөргөлдөөний үед ЕХ-ны менежмент хийх чадварыг бататгах, гишүүн орнуудын батлан хамгаалах чадварыг бэхжүүлэх, НАТО-д оруулах Европын хувь нэмрийг нэмэгдүүлэх явдал юм. Энэ зорилгодоо хүрэхийн тулд PESCO-гийн зүгээс гишүүн орнууддаа жил бүр батлан хамгаалах салбарын хөрөнгө оруулалт, зардлыг нэмэгдүүлж байх, батлан хамгаалах төлөвлөлтөө гишүүн улсууд хоорондоо уялдуулах, ур чадвараа хөгжүүлэх чиглэлд хамтын ажиллагааг эрчимжүүлэх зэрэг заавал биелүүлэх нийт 20 үүрэг хүлээлгэж, үүнийг тал бүрээс нь хэрэгжүүлэх 47 төрлийн хамтарсан төслийг эхлүүлээд байна. 2018 оны 3 дугаар сард эхний 17 төслийг эхлүүлсэн бол мөн оны 11 дүгээр сард дараагийн 17 төслийг эхлүүлсэн байна. Үүнд агаарын орон зайн 3 төсөл, сансрын орон зайн 2 төсөл, хуурай газрын хүчний 6 төсөл, тэнгисийн хүчний 4 төсөл, хамтын чадавхийг бэхжүүлэх 7 төсөл, нэгдсэн

сургалтын 5 төсөл, кибер аюулгүй байдлын 7 төсөл тус тус багтаж байна.<sup>14</sup> 2019 оны 11 дүгээр сард нэмж 13 шинэ төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна.<sup>15</sup>

ЕХ-ны батлан хамгаалах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэхэд PESCO-гоос гадна өөр хэд хэдэн төрлийн санаачилга, байнгын бүтцийг шинээр хэрэглэж байгаа бөгөөд PESCO санаачилга нь гишүүн орнуудын батлан хамгаалах салбарын зохион байгуулалт үйл ажиллагаанд чиглэсэн байдаг бол бусад нь батлан хамгаалахын төлөвлөлт, санхүүжилт гэх мэт төрөл бүрийн чиглэлд хэрэгжиж байна. Тухайлбал, үүнд:

- 2017 онд үүсгэн байгуулсан Coordinated Annual Review on Defence (CARD - Батлан хамгаалах салбарын жил бүрийн уялдуулсан хяналтын бүтэц) нь ЕХ-ны батлан хамгаалахын зардал, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөгөөг хянаж, дутагдалтай талыг илрүүлэхийн зэрэгцээ уялдаа холбоо сайтай төлөвлөлтүүдийг хийхэд дөхөм болох үүрэгтэй юм. CARD нь анхны бүрэн хэмжээний хяналтыг 2019 оны намраас эхлүүлээд байна.<sup>16</sup>
- 2017 онд байгуулсан Цэргийн төлөвлөлт, гүйцэтгэлийн штаб (Military Planning and Conduct Capability-MPCC) нь ЕХ-ны энхийг сахиулах

---

Europäischen Rat, den Rat, den Europäischen Wirtschafts- und Sozialausschuss und den Ausschuss der Regionen, Brüssel, 30.11.2016, COM (2016) 950 final.

13 Австри, Бельги, Болгар, Чех, Хорват, Кипр, Эстон, Финлянд, Франц, Герман, Грек, Унгар, Итали, Ирланд, Латви, Литва, Люксембург, Нидерланд, Польш, Португаль, Румын, Словень, Словак, Испани, Швед

14 The European Union's global strategy, three years on, looking forward, 17.06.2019, pp.13

15 Europäischer Rat, Rat der Europäischen Union, Zusammenarbeit der EU im Bereich der Sicherheit und Verteidigung, 06.03.2020, <https://www.consilium.europa.eu/de/policies/defence-security/>

16 The European Union's global strategy, three years on, looking forward, 17.06.2019, pp.36

цэргийн ажиллагааг удирдан зохион байгуулах нэгдсэн удирдлагын төв бөгөөд энхийг сахиулах иргэний ажиллагааны бүтэцтэй нягт хамтран ажилладаг. 2020 оны сүүлчээс МРСС нь энхийг сахиулах цэргийн ажиллагааг 1500 орчим бие бүрэлдэхүүнтэйгээр (battlegroup-ийн хэмжээнд) бие даан гүйцэтгэх чадвартай болохыг зорин ажиллаж байна.<sup>17</sup>

- 2017 онд үүсгэн байгуулсан Европын Батлан хамгаалахын сан (European Defense Fund) нь ЕХ-ны батлан хамгаалах салбарт хэрэгжүүлж буй өндөр технологийн болон судалгааны төслүүд, Европын батлан хамгаалах аж үйлдвэрийн төслүүдийг санхүүжүүлэх бөгөөд 2018-2020 онд Батлан хамгаалах судалгааны бэлтгэл арга хэмжээнд (Preparatory Action on Defence Research-PADR) 90 сая евро, 2019-2020 онд Европын батлан хамгаалах аж үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрт (European Defense Industrial Development Programme - EDIDP) 500 сая еврог татан төвлөрүүлэх, төслийг санхүүжүүлэх ажлыг эхлээд байна.<sup>18</sup> Европын Батлан хамгаалахын санд 2021-2027 онд нийт 13 их наяд еврогийн төсөв татах саналыг Европын Комисс оруулсан байна.<sup>19</sup>
- ЕХ нь НАТО-той 2016, 2018 онд хамтын ажиллагааны мэдэгдэл

байгуулж, кибер аюулгүй байдал, батлан хамгаалах аж үйлдвэр, судалгаа, цэргийн ажиллагаа гэх мэт 7 чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр тохирч, хэрэгжүүлж эхлээд байна.

*Гадаад бодлого, дипломатын салбар*

2016 оны ЕХ-ны Даян дэлхийн стратегид дурдсанчлан, дүрэм журамд тулгуурласан олон туйлт тогтолцоог (rules-based multilateralism) цаашид бэхжүүлэх нь ЕХ-ны нэн чухал сонирхлын нэг юм. Дүрэм журамд тулгуурласан олон туйлт тогтолцооны үед улс орнууд нэгдмэл зорилгодоо хамтын хүчээр хүрэхийн тулд, зөрчилдөж буй сонирхлыг тэнцвэржүүлэхийн тулд хоорондоо хамтран ажиллах, харилцан зохицуулах боломжтой байх буюу бүхий л улс орнууд хамгийн өндөр үр ашгийг хүртэх боломжтой байдаг гэж үздэг.<sup>20</sup> Иймд ЕХ-ны Зөвлөлөөс 2019 оны 6 дугаар сарын 17-нд дүрэм журамд тулгуурласан олон туйлт тогтолцоог (rules-based multilateralism: үүнийг цаашид мультилатерализм гэж товчлон бичнэ) цаашид бэхжүүлэх зорилгоор ЕХ-ны зүгээс авах арга хэмжээг Европын Зөвлөлийн зүгээс нэгтгэн дүгнэсэн байна.<sup>21</sup> Мультилатерализмын төлөө ЕХ-ны авч хэрэгжүүлж буй арга хэмжээг энд багцлан авч үзье.

17 Мөн тэнд, 34 дүгээр тал.

18 European Commission, Press release, European Defence Fund: EU funds new joint research and industrial projects, 06.04.2020, [https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/IP\\_20\\_595](https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/IP_20_595)

19 European Commission, Press release, EU budget: Stepping up the EU's role as a security and defence provider, Strasbourg, 13 June 2018, [https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/IP\\_18\\_4121](https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/IP_18_4121)

20 Hanns W.Maull, Multilateralism, SWP-Aktuell, Nr.11.Februar 2020, S.1-2.

21 EU action to strengthen rules-based multilateralism, Council conclusions 10258/19, 17 June 2019, S.5

- Нэгдүгээрт, мультилатерализмыг шинэчлэх, бүтээх, хэрэгжүүлэх, гүнзгийрүүлэх, ба хөрөнгө оруулалт хийх (reforming multilateralism, creating multilateralism, implementing multilateralism, deepening multilateralism, investing multilateralism) чиглэл,
- Хоёрдугаарт, хамтын ажиллагаанд чиглэсэн бүс нутгийн дэг журмыг (cooperative regional orders) бэхжүүлэх чиглэл гэсэн хоёр үндсэн чиглэлээр эрчимтэй явагдаж байна.<sup>22</sup>

Эхний чиглэлээр тухайлбал, сүүлийн жилүүдэд ЕХ-ны зүгээс НҮБ-ын системийн байгууллагуудад үзүүлэх санхүүгийн тусламжаа нэмэгдүүлсэн, 2018 онд “Хүний эрхийн төлөө – сайхан түүхүүд” санаачилгыг эхлүүлсэн, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр болон Каттовитцийн хэлэлцээрийг батлах, хэрэгжүүлэх ажилд тэргүүн эгнээнд идэвхтэй оролцсон бөгөөд цаашид үргэлжлүүлэн НҮБ-ын системийн байгууллага, ДХБ, ЕАБХАБ, Их 7-гийн уулзалт, Их 20-ийн уулзалт зэрэг олон улсын байгууллагуудыг шинэчлэх, олон улсын гэрээ хэлцэл, дүрэм журмыг сахиулахад нь тэдэнд дэмжлэг үзүүлэх, тодорхой асуудал бүрээр санаа нийлэх түншүүдтэй олон талын баг үүсгэн хамтран ажиллах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Хоёрдугаар чиглэлийн хувьд, НАТО-тай хамтын ажиллагаагаа 2016 оноос хойш эрс эрчимжүүлсэн, Грек-

Умард Македонийн хооронд түүхэн Преспа хэлэлцээрийг байгуулахад багагүй үүрэг гүйцэтгэсэн, Венесуэльд туслах олон улсын багийг үүсгэн байгуулж, үүнд 118 сая еврог зориулсан, мөн ЕХ нь Хойд мөсөн далайн эрэг дагуу орших 9 улстай Хойд мөсөн далайн төв хэсэгт арилжааны зориулалттай загас агнуур хийхийг хориглосон хэлэлцээрийг санаачлан байгуулсан, ЕХ-НҮБ-Африкийн холбооны гурвалсан түншлэлийг 2017 онд эхлүүлсэн гэх мэт олон ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнээс гадна ЕХ-ны орнуудын зүгээс стратегийн бие даасан байдлаа хангахын тулд гадаад бодлого, дипломатын чиглэлд авч хэрэгжүүлж буй нэгэн томоохон арга хэмжээ бол 2019 онд Герман, Францын санаачилгаар “Alliance for Multilateralism” хэмээх сайн дурын холбоог байгуулсан явдал юм. Өдгөө уг холбоонд дэлхийн 50 гаруй улс (Америк, Хятад, Оросоос бусад ихэвчлэн бүс нутгийн гүрнүүд болон хөгжиж буй орнууд) нэгдээд байгаа бөгөөд энэ нь дүрэм журамд тулгуурласан олон улсын дэг журмыг тогтворжуулахын төлөө дэлхий нийтийн хүлээх үүрэг хариуцлагыг шинэчлэн тогтоох, зарчмуудаа мөрдөх, шаардлагатай нөхцөлд тэдгээрийг шинэчлэхийг зорилгоо болгож байна.<sup>23</sup>

Үүнээс үзэхэд, ЕХ цаашид олон улсын тавцанд нээлттэй, тодорхой байр суурийг баримталж, олон улсын эрх зүй, НҮБ-ын дүрэм, Хүний

22 The European Union's global strategy, three years on, looking forward, 17.06.2019, pp.15-16

23 Alliance for Multilateralism, What is the „Alliance for Multilateralism“?, <https://multilateralism.org/the-alliance/>



эрхийн түгээмэл тунхаглалд тусгасан зарчмууд, эрх зүйт төр, тогтвортой хөгжлийн зарчмуудыг дэлхий дахинаа хэрэгжүүлэхийн төлөө идэвх санаачлагатай ажиллахаас гадна үүнийг зөрчсөн тохиолдолд үүний эсрэг чанга дуугарч, бодит хариу үйлдэл үзүүлдэг болох төлөв харагдаж байна. Чингэхдээ ЕХ нь Канад, Австрали, Энэтхэг, Бразил, Индонез, Япон, Мексик, Өмнөд Солонгос<sup>24</sup> зэрэг хүч чадавхи, нөлөө нь өсөн нэмэгдэж буй улс орнуудтай нягт хамтран ажиллах, улс хоорондын хамтын ажиллагаанд шаардлагатай нөхцөлд төрөл бүрийн хориг арга хэмжээг түлхүү хэрэглэх хандлагатай байна.

#### *Эдийн засаг, технологийн салбар*

2016 оны ЕХ-ны Даян дэлхийн стратегид “Гишүүн орнууд бие даан үйл ажиллагаа явуулах чадвартай болохын тулд техникийн болон аж үйлдвэрийн хөрөнгө хүч хэрэгтэй”<sup>25</sup> талаар дурдсан байдаг ч ихэвчлэн батлан хамгаалах аж үйлдвэрийг хөгжүүлэх, үүнтэй холбоотойгоор шинэ техник, технологи, судалгааг

хөгжүүлэх асуудалд төвлөрч байна. Үүний дараа 2019 оны 12 дугаар сард Европын Комиссоос “Европын ногоон хэлцэл”,<sup>26</sup> 2020 оны 2 дугаар сард “Европын дижитал ирээдүйг бүтээн байгуулах нь”<sup>27</sup> баримт бичгийг, 2020 оны 3 дугаар сарын 10-нд “Европын аж үйлдвэрийн шинэ стратеги”-ийг тус тус батлан гаргасан байна.<sup>28</sup>

“Европын аж үйлдвэрийн шинэ стратеги” нь ЕХ-г дижитал хөгжлийн хувьд дэлхийд тэргүүлэх төвшинд хүргэхийн зэрэгцээ уур амьсгалд сөрөг нөлөөгүй, байгаль орчинд ээлтэй болгохыг зорьж байна. Гэвч геополитикийн нөхцөл байдал өөрчлөгдөж буйтай холбоотойгоор дэлхий дахинаа худалдааны харилцаанд хурцадмал байдал, өрсөлдөөн, зах зээлийн өөрчлөлт, протекционизм улам бүр нэмэгдэж буй нь ЕХ уг шинэ стратегийн хүрээнд экологийн болон дижитал өөрчлөлтийг хийхдээ, нөхцөл байдалд тохируулан бууж өгөх маягаар бус харин эдийн засгаа нээх, нөгөө талаар эдийн засгийн дипломат бодлого явуулах замаар өөрчлөлтийг хийх ажээ. Дэлхийн зах зээл нээлттэй,

24 Barbara Lippert, Nicolai Ondarza, Volker Perthes, Strategische Autonomie Europas, Akteure, Handlungsfelder, Zielkonflikte, SWP-Studie, 2 Februar 2019, Berlin, S.34

25 Eine globale Strategie für Außen- und Sicherheitspolitik der EU, Juni 2016, S.16.

26 “Европын ногоон хэлцэл” баримт бичиг нь 2050 он гэхэд Европ тивийг байгаль орчинд ээлтэй, уур амьсгалд сөрөг нөлөөгүй анхны тив болгох стратеги юм.

Der Europäische Grüne Deal, Mitteilung der Europäischen Kommission an das Europäische Parlament, den Europäischen Rat, den Rat, den Europäischen Wirtschafts- und Sozialausschuss und den Ausschuss der Regionen, COM (2019)640 final, Brüssel, 11.12.2019.

27 Энэ нь Европ хэрхэн технологийн ба дижитал бие даасан байдлаа хангах, дижитал хөгжлөөр дэлхийд тэргүүлэх төвшинд хүргэх тухай стратеги юм.

Gestaltung der digitalen Zukunft Europas, Mitteilung der Europäischen Kommission an das Europäische Parlament, den Europäischen Rat, den Rat, den Europäischen Wirtschafts- und Sozialausschuss und den Ausschuss der Regionen, COM (2020)67 final, Brüssel, 19.02.2019.

28 Eine neue Industriestrategie für Europa, Mitteilung der Kommission an das Europäische Parlament, den Europäischen Rat, den Rat, den Europäischen Wirtschafts- und Sozialausschuss und den Ausschuss der Regionen, COM (2020) 102 final, Brüssel, den 10.03.2020.

өрсөлдөөнийг шударга байлгахад дүрэм журамд тулгуурласан олон талт худалдааны тогтолцоо болон ДХБ оршин байх зайлшгүй шаардлагатай юм. Иймд ЕХ нь цаашид дэлхийн худалдааны тогтолцоог хадгалах, шинэчлэх, өргөтгөхийн төлөө ажиллах ажээ. Ингэсэн нөхцөлд л ЕХ стратегийн бие даасан байдал, аж үйлдвэрийн өрсөлдөх чадвараа бататгах боломжтой болох ажээ.<sup>29</sup>

“Европын аж үйлдвэрийн шинэ стратеги” баримт бичигт, Европын аж үйлдвэрийн болон стратегийн бие даасан байдлыг хэрхэн бэхжүүлэх тухай тусгайлсан бүлэг оруулсан бөгөөд үүнд стратегийн чухал ач холбогдолтой салбарт гаднаас хараат байдлыг бууруулах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хянах хүрээг нэмэгдүүлэх, эрчим хүчний бус түүхий эдийн хангамжийг нэмэгдүүлэх гэх мэт арга хэмжээг авахаар дурджээ.

Дүгнэн хэлэхэд, гадаад бодлогын хувьд хүч нөлөөтэй байх гол үндэс нь эдийн засгийн хүч чадавхи байдаг<sup>30</sup> учраас эдийн засаг, технологийн салбар нь ЕХ стратегийн бие даасан байдлаа хангах нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг гарцаагүй мөн юм.

## Европын Холбоо ба Монгол Улс

Гадаад тааламжгүй орчны улмаас өдгөө ЕХ стратегийн бие даасан байдлаа хангахаар зорьж байгаа нь Монгол Улс ба Европын Холбооны хоёр талын харилцааг эерэг, сөрөг аль ч талаар идэвхжүүлж байна гэж дүгнэж байна.

Нэг талаас иргэдийнхээ аюулгүй байдал, эдийн засгийн хангалуун амьдралыг хангахын тулд Төв Азид чиглэсэн стратегийн сонирхлын хүрээнд, нөгөө талаас дүрэм журамд тулгуурласан, олон туйлт дэлхийн шинэ дэг журмыг тогтоох ЕХ-ны сонирхлын хүрээнд ЕХ нь Монгол Улсад ардчиллын үнэт зүйлсийг эн тэргүүнд бэхжүүлэх бодлогоо улам бататган баримтлах төлөвтэй байна. Нөгөө талаас, хэрэв Монгол Улс ардчилал, хүний эрх, эрх чөлөө, эрх зүйт төр зэрэг үнэт зүйлсдээ ноцтой хохирол учруулах аваас үүнийг эсэргүүцэн ЕХ-ны зүгээс зохих арга хэмжээг авах төлөв ажиглагдаж байна. Үүнд эдийн засгийн хориг арга хэмжээ авах, хөл хориг тавих, Европын банк санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа хөрөнгийг царцаах зэрэг алхмууд байх болно. Үүний нэгэн тод жишээ гэвэл 2017 оны сүүлчээр Монгол Улсын татварын орчны ил тод байдал хангалтгүй байгаагийн улмаас ЕХ Монгол Улсыг татварын асуудлаар хамтран ажилладаггүй орнуудын хар жагсаалтанд оруулсан явдал юм. Мөн

29 Eine neue Industriestrategie für Europa, Mitteilung der Kommission an das Europäische Parlament, den Europäischen Rat, den Rat, den Europäischen Wirtschafts- und Sozialausschuss und den Ausschuss der Regionen, COM (2020) 102 final, Brüssel, den 10.03.2020.

30 Barbara Lippert, Nicolai Ondarza, Volker Perthes, Strategische Autonomie Europas, Akteure, Handlungsfelder, Zielkonflikte, SWP-Studie, 2 Februar 2019, Berlin, S.16

өдгөө ЕХ-нд Монгол Улсыг дахин хар жагсаалтанд оруулах асуудал яригдаж байна. Үүнээс гадна, хэрэв 2008 оны 7 дугаар сарын 1-нд гарсан шиг хүний эрхийг зөрчсөн үйл явдал Монголд дахин давтагдах ахул ЕХ үүнийг өмнөх шигээ дуугүй өнгөрөөх бус харин Монгол Улсын эсрэг хориг арга хэмжээ авах зэрэг сөрөг хариу үйлдэл үзүүлж болзошгүй гэсэн үг юм.

Нөгөө талаас, Монгол Улс газарзүйн чухал байрлалтай болохынхоо хувьд ЕХ-ны сонирхлыг татаж байдаг төдийгүй ардчиллын үнэт зүйлсийг баримталдаг тул ЕХ Монгол Улстай харилцаагаа эерэгээр бодитой идэвхжүүлэх хандлагатай байна. Тодруулбал, олон жил хүлээлгэсний эцэст 2017 онд ЕХ нь Монгол Улстай байгуулсан “Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг хүчин төгөлдөр болгох шийдвэрийг гаргасан төдийгүй Улаанбаатар хотноо ДТГ-аа нээгээд байна.

Эцэст нь 2020 оны 3 дугаар сард батлагдсан “ЕХ-ны аж үйлдвэрийн шинэ стратеги”-д дурдсанаар, Европын аж үйлдвэрийн салбарт экологийн болон дижитал өөрчлөлтийг хийх үед ЕХ-нд эрчим хүчний бус эрдсийн гаралтай түүхий эдийн эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэх бөгөөд 2050 он гэхэд ийм түүхий эдийн хэрэгцээ бараг хоёр дахин өсөх төдийгүй эдгээрийн ихэнхийг гуравдагч орнуудаас авах шаардлага гарах ажээ. Иймд цаашид ЕХ-ноос эдгээр хэрэгцээт түүхий эдийг олон улсын түншлэлийг хөгжүүлэх замаар олж авах тухай үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах төлөвтэй байна.<sup>31</sup> Үүнтэй холбоотойгоор Монгол Улс ба ЕХ, түүний гишүүн орнуудын хооронд уул уурхайн салбарын хамтын ажиллагаа идэвхжих магадлалтай байна.

## Дүгнэлт

1. ЕХ-ны хилийн гадна, дотно өрнөж буй хямрал зөрчлүүд Европын иргэдийн амьдралд нөлөөлж, улмаар Холбооны оршин тогтнолд сорилт болж байгаа тул 2016 оноос хойш тус холбоо стратегийн бие даасан байдалд хүрэх бодлого баримтлан ажиллаж байна. ЕХ ард иргэдийнхээ хангалуун сайхан амьдралыг хадгалан үлдэхэд шаардагдах олон улсын харилцааны таатай орчин, дүрэм журам бүхий дэлхийн дэг журмыг тогтооход өөрсдөө хамтран эс оролцох аваас өөр бусдын тогтоосон ямар нэгэн дүрмэнд захирагдах хэрэг гарах учраас стратегийн бие даасан байдлыг эн тэргүүнд хангах шаардлагатай болжээ.
2. ЕХ-ны стратегийн бие даасан байдал гэдгийг өөрийгөө хамгаалах чадвартай зэвсэгт хүчинтэй байх, зэвсэгт хүчнээ шаардлагатай зэвсэг тоноглолоор хангах аж үйлдвэрийн хүчин чадалтай байх, зайлшгүй нөхцөлд бие даасан шийдвэр гаргах

31 Eine neue Industriestrategie für Europa, Mitteilung der Kommission an das Europäische Parlament, den Europäischen Rat, den Rat, den Europäischen Wirtschafts- und Sozialausschuss und den Ausschuss der Regionen, COM (2020) 102 final, Brüssel, den 10.03.2020, S.17-18.

улс төрийн чадвар чадавхитай байх явдал гэж үзэж, үүний дагуу батлан хамгаалах, гадаад бодлого-дипломатын салбар, эдийн засаг технологийн салбар гэсэн үндсэн гурван чиглэлд ихээхэн өөрчлөлтийг хийж, эрчимтэй арга хэмжээ авч байна.

3. ЕХ стратегийн бие даасан байдлаа хангахаар зорьж байгаа нь Монгол Улс ба Европын Холбооны хоёр талын харилцааг эерэг, сөрөг аль ч талаар идэвхжүүлж байна гэж дүгнэж байна.

### Ашигласан материал

Alliance for Multilateralism, What is the „Alliance for Multilateralism“?, <https://multilateralism.org/the-alliance/>

Barbara Lippert, Nicolai Ondarza, Volker Perthes, Strategische Autonomie Europas, Akteure, Handlungsfelder, Zielkonflikte, SWP-Studie, 2 Februar 2019, Berlin

Der Europäische Grüne Deal, Mitteilung der Europäischen Kommission an das Europäische Parlament, den Europäischen Rat, den Rat, den Europäischen Wirtschafts- und Sozialausschuss und den Ausschuss der Regionen, COM (2019)640 final, Brüssel, 11.12.2019

Eine globale Strategie für Außen- und Sicherheitspolitik der EU, Juni 2016

Eine neue Industriestrategie für Europa, Mitteilung der Kommission an das Europäische Parlament, den Europäischen Rat, den Rat, den Europäischen Wirtschafts- und Sozialausschuss und den Ausschuss der Regionen, COM (2020) 102 final, Brüssel, den 10.03.2020

EU action to strengthen rules-based multilateralism, Council conclusions 10258/19, 17 June 2019

European Commission, Press release, European Defence Fund: EU funds new joint research and industrial projects, 06.04.2020, [https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/IP\\_20\\_595](https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/IP_20_595)

European Commission, Press release, EU budget: Stepping up the EU’s role as a security and defence provider, Strasbourg, 13 June 2018, [https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/IP\\_18\\_4121](https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/IP_18_4121)

Europäischer Verteidigungs- Aktionsplan, Mitteilung der Kommission an das Europäische Parlament, den Europäischen Rat, den Rat, den Europäischen Wirtschafts- und Sozialausschuss und den Ausschuss der Regionen, Brüssel, 30.11.2016, COM (2016) 950 final.

Europäischer Rat, Rat der Europäischen Union, Zusammenarbeit der EU im Bereich der Sicherheit und Verteidigung, 06.03.2020, <https://>

- [www.consilium.europa.eu/de/policies/defence-security/](http://www.consilium.europa.eu/de/policies/defence-security/)
- Gestaltung der digitalen Zukunft Europas, Mitteilung der Europäischen Kommission an das Europäische Parlament, den Europäischen Rat, den Rat, den Europäischen Wirtschafts- und Sozialausschuss und den Ausschuss der Regionen, COM (2020)67 final, Brüssel, 19.02.2019
- Hanns W.Maull, Multilateralismus, SWP-Aktuell, Nr.11.Februar 2020
- Hanns W.Maull (Hrsg.), Auflösung oder Ablösung? Die internationale Ordnung im Umbruch, SWP-Studie, Dezember 2017, Berlin
- Heidelberg Institute of International Conflict research, Conflict barometer 2019, Heidelberg 2020
- Jahresbericht über die Umsetzung der Gemeinsamen Sicherheits- und Verteidigungspolitik, P9\_TA(2020)0009 Entschließung des Europäischen Parlaments vom 15. Januar 2020 über die Umsetzung der Gemeinsamen Sicherheits- und Verteidigungspolitik (2019/2135(INI)), 15.01.2020
- Rede von Außenminister der BRD Sigmar Gabriel in der Körber-Stiftung, „Europa in einer unbequemeren Welt“, 05.12.2017
- Schlussfolgerungen des Europäischen Rates (Tagung vom 19./20. Dezember 2013), EUCO 217/13, Brüssel, 20.12.2013
- The European Union`s global strategy, three years on, looking forward, 17.06.2019

## European Union strategic autonomy and Mongolia

**Lkham Tsermaa**

*Researcher, PhD*

*The Institute of International Affairs, Mongolian Academy of Sciences*

*Ulaanbaatar, Mongolia*

*Email: lkham\_ts@mas.ac.mn*

**Abstract:** *Under the objective to ensure its strategic autonomy set in 2016, the European Union is undertaking changes in common foreign and security policy, defense, economic and technological areas. In this article, the author not only examines these changes, but also expresses her views on how they may affect the relations between Mongolia and the EU.*

**Keywords:** *the European Union, strategic autonomy, partnership between Mongolia and the European Union*

*The day of submission:* 2020.5.13

*Completion of review:* 2020.6.18

*Final decision for acceptance:* 2020.6.20